



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2022.07.29 № 32

“Дархан арьс ширний цогцолбор”-ийн
үйл ажиллагааны талаар

Монгол Улсын эдийн засаг, ХАА-н салбарт жинтэй хувь нэмэр оруулах “Дархан арьс ширний цогцолбор” төслийн ТЭЗҮ-ийг боловсруулан эрх бүхий байгууллагаар батлуулан шав тавьж, бүтээн байгуулалтын ажил эхлээд 3 дахь жилдээ орж байна. ТЭЗҮ-д тусгаснаар уг цогцолбор үйлдвэр нь жилд 10 сая ширхэг арьс шир, 11000 тонн ноос, ноолуур боловсруулж дэлхийн стандартад нийцсэн нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн процесст 2300 ажлын байр шинээр бий болгохоор төлөвлөгдсөн байдаг. Дархан-Уул аймгийн төдийгүй бүс нутгийн ажилгүйдлийн түвшин буурах, мал аж ахуйн гаралтай түүхийг эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах, нэмүү өртөг шингээх, экспортын хэмжээ нэмэгдэх, валютын ханш тогтворжих зэрэг олон эерэг үр дүнг дагуулахаар төлөвлөгдсөн томоохон хэмжээний төсөл юм.

Засгийн газрын 2020 оны 234 дүгээр тогтоолоор “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” ТӨХХК-ийг байгуулж дүрмийг баталсан. Өдгөө тус байгууллага төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гүүр болж төслийг хэрэгжүүлэх, урагшлуулахад ямар нэгэн хувь нэмэр оруулаагүй гэж дүгнэгдэхээр байна. Учир нь Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны 12-р сарын 31-ны өдрийн А/127 тоот тушаалаар баталгаажуулсан хавсралт тайланд төслийн хүрээнд захиалагч болон гүйцэтгэгч нь бүтээн байгуулалтын ажилд 24,855.2 сая төгрөгийн өөрийн хөрөнгийг зарцуулжээ гэж тусгагджээ. Гэвч санхүүжилт байхгүйн улмаас 2020 оны 8 дугаар сараас эхлэн төслийн ажил зогссон байна.

Иймд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого буюу “Алсын хараа 2050”, дунд хугацааны хөгжлийн бодлого “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан “ДАРХАН АРЬС ШИРНИЙ ЦОГЦОЛБОР” төсөл ямар шалтгаанаар зогсонги байдалд байгааг тодруулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

2022000082

1. “Дархан арьс ширний цогцолбор” ОНӨХХК-ийн хэрэгжүүлж буй ДАРХАН АРЬС ШИРНИЙ ЦОГЦОЛБОР төслийн үйл ажиллагаа ямар шалтгаанаар зогсонги байдалд орсон талаар;


2. Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан “Дархан арьс ширний цогцолбор” ОНӨХХК-ийн хэрэгжүүлэх “Арьс ширний цогцолбор” байгуулах төслийн талаар МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар;

3. Засгийн газрын 2020 оны 234 дүгээр тогтоолоор “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” ТӨХХК болон “Дархан арьс ширний цогцолбор” ОНӨХХК-ийн хамтын ажиллагаа буюу төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд цаашид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх зэрэг болно.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлэх, цаашид 2022 оны Улсын Их Хурлын намрын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б. БАТТӨМӨР

2022000082